



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 565

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ховд АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 66,886,956.00 (жаран зургаан сая найман зуун наян зургаан мянга есөн тавин зургаан) төгрөгийн балансын үнэ, 60,780,352.7 (жаран сая долоон зуун наян мянга гурван зуун тавин хоёр төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаангомьн хоёрдугаар дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Ховд-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батсүх, Улаангомьн хоёрдугаар дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ю.Сайнжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001122

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 16 өдрийн
86 дугаар тогтоолын хавсралт

"ХОВД АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИАС "УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ" ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Эксватор CAT438	2004/2009	66,886,956.00	60,780,352.70	6,106,603.30
НИЙТ ДҮН			66,886,956.00	60,780,352.70	6,106,603.30
			(жаран зургаан сая найман зуун наян зургаан мянга есөн тавин зургаан)	(жаран сая долоон зуун наян мянга гурван зуун тавин хоёр төгрөг далан мөнгө)	(зургаан сая нэг зуун зургаан мянга зургаан зуун гурван төгрөг гучин мөнгө)